

ДӨРӨВ. БАГШИЙН АКАДЕМИК СОЁЛ, ЁС ЗҮЙН ХЭМ ХЭМЖЭЭГ МӨРДӨХ, ХУВЬ ХҮНИЙ МЭДЛЭГ, ЧАДВАР, ХАНДЛАГЫГ ХӨГЖҮҮЛЭХ

4.1. Хувь хүний хөгжил, төлөвшлийг дэмжих, алхалтын клуб

Хувь хүний хөгжлийг дэмжиж ажиллах зорилгоор багш нарын англи хэлний мэдлэгийн түвшин тогтоох шалгалтыг авч, сургалтыг зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна. Хувь хүний болон байгууллагын соёлыг төлөвшүүлэх зорилгоор урлаг, спортын арга хэмжээг жил бүр тогтмол зохион байгуулж бүх багш нарыг хамруулдаг. Мөн багшийн ажлын байрны нийгэм сэтгэлзүйн болон зөв зохистой хооллолтын чиглэлээр дараах ажлуудыг хэрэгжүүлж байна. Үүнд:

1. НЭМС-аас АШУҮИС-ийн удирдах ажилтнуудад зориулан Байгууллагын удирдлага, зохион байгуулалт, ёс зүй сэдэвт сургалт;
2. "Эрсдэлт зан үйлийг өөрчлөх стратеги" сургалт
3. Ажлаас халшрах хам шинж
4. Бие хүний сэтгэл зүйн хувийн онцлог шинжүүд: Темперамент, зан төлөв, авъяас, сонирхол, сэдэл, хэрэгцээ
5. "Багшийн ажлын ёс зүй" сургалт
6. "Ажлын байрны стресс" сургалт /тотмол/
7. "Судалгааны ёс зүй" сургалт /тотмол/
8. "Ахмад настны сэтгэлзүйн эрүүл мэнд"
9. "Хувь хүний санхүүгийн удирдлага"
10. "Өрхийн санхүүгийн удирдлага"
11. "Зөв зохистой хооллолт"-ын сургалтуудийг АШУҮИС-ийн нийт багш ажилтнуудад зориулан явуулсан.

Их сургуулийн цайны газартай холбоотой хийгдсэн ажлууд:

АШУҮИС-ийн харьяа эмнэлгүүдийн хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газрын удирдлага, хоол зүйч, хоолны технологич, тогооч, туслах ажилтнуудад зориулсан сургалт, хэлэлцүүлэг зохион байгуулах ажлын хүрээнд Их Сургуулийн Сургалтын Нэгдсэн Эмнэлэг, Монгол-Японы Эмнэлэг, Монгол Анагаах Ухааны Төв Эмнэлгийн хоол үйлдвэрлэл хариуцсан нэгжүүдтэй Нийгмийн Эрүүл Мэндийн сургуулийн Шим Тэжээл Судлалын тэнхим дотоод шалгалтыг 2 удаа гүйцэтгэсэн. Жил бүр их сургуулийн цайны газар болон эмнэлэгийн хоол үйлдвэрлэлийн газрын удирдлага, хоол зүйч, ахлах тогооч, туслах тогооч, технологич нарт зориулсан сургалтыг тогтмол зохион байгуулан ажиллаж байна. Мөн цайны газар солигдох бүрт үйл ажиллганы чиглэлтэй танилцаж, гэрээг хамтран байгуулдаг.

АШУҮИС-ийн төв байрны цайны газрын хоолны илчлэг, шим тэжээлийг тооцож, 13 нэр төрлийн хоолонд уураг, өөх тос, нүүрс ус, илчлэгийг лабораторийн шинжилгээгээр тодорхойлсон. Үр дүнг тооцоолж, 13 нэр төрөл хоолны мэдээлэл агуулсан постерийн эхийг бэлдэж, хэвлүүлсэн.

Багш нар хөтөлбөр, нийгэмлэг, зөвлөлийн гигүүнээр ажиллах:

Багшийн хөгжил хөтөлбөрийн 4.3.3-д "Жил бүр мэргэжлийн салбар, нийгэмлэг, холбоодыг дэмжсэн үйл ажиллагааг тогтмол зохион байгуулснаар багш, эмч нарын мэргэжлийн нийгэмлэг, холбоодын гишүүнчлэл нэмэгдэнэ" гэсэн заалт болон 4.5.5-д "Багшийн хөгжлийн чиглэлээр хамтран ажиллах төрийн болон хувийн хэвшлийн байгууллагын тоог

нэмэгдүүлэх” ажлын хүрээнд НЭМС-ийн багш нар дараах ОУ-ын байгууллагын 12 нийгэмлэг холбоонд, дотоодын 32 байгууллагад зөвлөх болон гишүүнчлэлээр ажиллаж байна.

№	Гишүүнчлэл / зөвлөх
1	АШУҮИС-ийн нэр томъёоны зөвлөлийн гишүүн
2	НЭМ-ийн мэргэжлийн салбар хорооны гишүүн
3	АШУҮИС-ийн хөтөлбөрийн хорооны гишүүн
4	АШУҮИС-ийн хөтөлбөрийн дэд хорооны гишүүн
5	АШУҮИС-ийн хөтөлбөрийн магадлан итгэмжлэлийн ажлын хэсгийн гишүүн
6	АШУҮИС-ийн "Багшийн хөгжил хөтөлбөрийн" гишүүн
7	АШУҮИС-ийн "Оюутны хөгжил хөтөлбөрийн" гишүүн
8	АШУҮИС-ийн "Хөдөлмөрч оюутан" дэд хөтөлбөрийн гишүүн
9	АШУҮИС-ийн "Үлгэрлэгч оюутан" дэд хөтөлбөрийн гишүүн
10	ЭМЯ-ны дэргэдэх Эрүүл мэндийг дэмжих сангийн гишүүн
11	ЭМЯ-ны дэргэдэх Удам зүйн салбар хорооны гишүүн
12	ЭМЯ-ны НЭМ-ийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн
13	БШУЯ-ны ШУТ-ийн ажлын хэсгийн гишүүн
14	Нийгмийн Эрүүл Мэндийн Эрин сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүн
15	Өрхийн анагаах ухаан сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүн
16	ДЭМБ, ЭМЯ Усны аюулгүй байдлын төлөвлөгөөний үндэсний зөвлөх
17	ДЭМБ-ын НДБЭБ-ийн Гепатитын Зөвлөх хорооны гишүүн
18	МУ-ын Дархлаажуулалтын Зөвлөх Хорооны гишүүн
19	Монголын хоолзүйч, найрамдал холбооны гишүүн
20	“Хоолзүй шим судлалын Монголын нийгэмлэг”-ийн гишүүн
21	“Эрүүл амьдралын жигүүр” ТББ-д гишүүн
22	Member, National Committee of Immunization, Mongolia, since 2012-
23	Member, Professional Committee of Public Health, MOH, Mongolia
24	Vice Head, Scientific Committee of the School of Public Health
25	Assistant Editor, Mongolian Journal of Health Sciences (English)
26	ЭМЯ-ны дэргэдэх Эрүүл мэндийн удирдлага, эдийн засгийн мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн
27	Макро эдийн засаг ба эрүүл мэнд холбооны гишүүн
28	Монголын Орчин ба Хөдөлмөрийн Эрүүл мэндийн нийгэмлэг, тэргүүн
29	Монголын Хөдөлмөрийн Эрүүл Ахуйчдын Үндэсний Холбоо, удирдах зөвлөлийн гишүүн
30	Эмнэлгийн менежерүүдийн холбоо
31	ЭМЯ-ны Хор судлалын мэргэжлийн салбар зөвлөлийн гишүүн
32	ЭМЯ-ны НЭМ-ийн салбар зөвлөлийн гишүүн
	Олон улсын нийгэмлэг холбоод
33	Representative from Mongolia, Executive Committee Member, Asian Pacific Organization for Cancer Prevention, since April 2016-/current/
34	Member, Hepatitis B Expert Resource Panel (ERP), Western Pacific Regional Office of the World Health Organization, since 2011-/current/
35	Member, the Brighton Team, Brighton Collaboration (Vaccine safety), Switzerland
36	Member, International Epidemiologic Association
37	Member, American Public Health Association
38	Member, Japan Epidemiologic Association

39	Member, Japan Public Health Association
40	Central Asian Journal of Medical Sciences сэтгүүлийн редакцийн зөвлөлийн гишүүн
41	Member, National Committee of Immunization, Mongolia
42	Member, American Industrial Hygiene Association
43	International Society of Environmental Epidemiology
44	Birth Cohort Concoitioun of Asia

4.2. Хөдөлмөр эрхлэгчийн ажил, нийгмийн халамжтай холбоотой хууль эрх зүйн орчны сургалтуудыг мэргэжлийн яам байгууллагаас зохион байгуулах

Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг иргэдэд ойртуулах зорилгоор НЭМС-ийн цахим хуудас, нүүр ном (facebook)-д орох мэдээллийг бэлтгэн ажиллуулж байгаа ба олон нийтэд чиглэсэн томоохон хэмжээний олон арга хэмжээг зохион байгуулахаас гадна сайтаар дамжуулан ажил, нийгмийн халамжтай холбоотой мэдээллүүдийг байршуулдаг.

1. ЭМЯ-ын эмнэлгийн мэргэжилтний ёс зүйн хяналтын хороотой хамтран Гамшгийн үеийн эмнэлгийн мэргэжилтний ёс зүй сэдэвт 2 багц цагийн сургалтыг 4,5,6-р сард хамтран зохион байгуулж 7 аймаг, 7 дүүргийн 1600 гаруй хүнийг хамруулсан.
2. Авлигын эсрэг хууль, авлигатай тэмцэх үйл ажиллагааны талаар АТГ-аас зохион байгуулсан сургалтанд багш нараа хамруулсан.
3. НЭМС-аас АШУҮИС-ийн удирдах ажилтнуудад зориулан Байгууллагын удирдлага, зохион байгуулалт, ёс зүй сэдэвт сургалтыг зохион байгуулсан.
4. ЗХНГ-тай хамтран “Хөдөлмөрийн тухай” хууль, АШУҮИС-ийн хөдөлмөрийн дотоод журмын талаар сургалтад хамруулсан.